



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 2 өдөр

Дугаар 562

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Өвөрхангай-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 64,695,752.45 (жаран дөрвөн сая зургаан зуун ерэн таван мянга долоон зуун тавин хоёр төгрөг дөчин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Өвөрхангай-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Лхам-Оролмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг томилон үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001466

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн
56 дугаар тогтоолын хавсралт

**"Өвөрхангай-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн
жагсаалт**

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэр лэсэн он	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	Прадо маркийн 79-88 ӨВА улсын дугаартай, суудлын автомашин, Арлын дугаар- RZJ950016604	2007	22,540,271.00	3,599,227.00	4,500,000.00
2	Ниссан навара маркийн 36-42 ОВО улсын дугаартай, хагас суудлын автомашин, Арлын дугаар - MNTCCUD40Z0004942	2010	42,155,481.45	4,865,500.00	3,500,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		64,695,752.45 (жаран дөрвөн сая зургаан зуун ерэн таван мянга долоон зуун тавин хоёр төгрөг дөчин таван мөнгө)	8,464,727.00 (найман сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга долоон зуун хорин долоон)	8,000,000.00 (найман сая)